# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

АРВАННЭГДҮГЭЭР САР 2017

## ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт*

ДНБ
5.8%
2017 оны 3-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
6.5%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2448.86төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
**-980 тэрбум төг**

ГАДААД ХУДАЛДАА
**1781 сая төг**

## ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

*Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.*

*Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо*

## ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт*

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
**1.6 ТЭРБУМ ТӨГ**

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
**8.5%**

НИЙТ ХАДГАЛАМЖ
**11 ИХ НАЯД ТӨГ**

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС
**1.011 НЭГЖ**

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
**824 ТЭРБУМ ТӨГ**

ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО
**90 ӨРХ**

## ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +4.0%, 2018 онд: +3.0%
Инфляци: 2017 онд:+3.0%, 2018 онд +3.4%
Урсгал тэнцэл: 2017 онд ДНБ-ий -6.4%, 2018 онд: -8.5%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zwQ36D

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +2%, 2018 онд: +2.5%
Инфляци: 2017 онд: +4.4%, 2018 онд: +6%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2017 онд: -4.9%, 2018 онд: -8.7%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа 10-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo



www.facebook.mn/ecrcmn; www.twitter.com/ursulduhchadvar; www.ecrc.mn; утас: 976-11-321927

# ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 11-р сарын байдлаар (980) тэрбумын алдагдалтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 27.7 хувиар өсч, зарлага 3.8 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 980 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн сараас 311 тэрбумаар нэмэгдсэн үзүүлэлт юм. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 63.4 хувь буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас харьцангуй буурав.**

Тус сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 14 төгрөг буюу 0.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 9 төгрөг буюу 0.4 хувиар буурч 2448.86 төгрөг болов.

**Инфляцийн түвшин 6.5 хувь өсөв.**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2017 оны 11-р сард өмнөх сараас 0.1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өсч, өмнөх оны эцсээс 6.5 хувиар өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, орон сууц, ус, цахилгаан үнэ хамгийн их өссөн байна.




**Гадаад худалдааны тэнцэл 1781 сая.ам доллар болов.**

2017 оны эхний арван нэгэн сарын байдлаар нийт барааны эргэлт 9591 тэрбум төгрөг буюу 30 хувиар өсөв. Экспорт өмнөх сараас 6.2 хувиар буурч, импорт өмнөх сараас 0.7 хувиар буурч худалдааны тэнцэл 1781 сая ам.долларын ашигтай гарлаа.



## 11-Р САРЫН ОНЦЛОХ: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

ДНБ 2017 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 695 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 5.8% өсөв. Бүтээгдэхүүний цэвэр татвар 15%, үйлчилгээний салбар 7% өссөн нь голлон нөлөөлөв. Статитикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 193.3 тэрбум төгрөгөөр буурч эдийн засгийн өсөлт 1.4% болсон. Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15%, үйлчилгээний салбар 5%-иар буурахад нөлөөлжээ.

2017 он гарснаар эдийн засгийн өсөлт 4.3% өсөхөд дэлхийн зах зээлд экспортын гол нэрийн бараа болох нүүрс, алтны экспортын үнэ нэмэгдэж гадаад худалдаа 2017 оны эхний улиралд 524 сая ам.долларын ашигтай гарснаар, нүүрсний экспортын орлого 5.4 дахин өсч, банкны чанаргүй зээлийн хэмжээ буурахад нөлөөлөв. Хүснэгтээс харахад 2017 оны 2-р улиралд ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 398.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засаг 5.6 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Азийн хөгжлийн банкнаас ДНБ-ий өсөлт 2017 онд 4 хувиар, 2018 онд 3 хувиар өснө гэсэн прогноз гаргаад буй. Харин нэг хүнд ногдох дотоодны нийт бүтээгдэхүүн (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5301.7 мянган төгрөг буюу 2568.9 ам.доллар (ДБ-ий Атласын аргаар) байгаа юм. Энэ нь 2015 оноос буурсан үзүүлэлттэй байна.

## САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ, ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ

- "Fitch" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B" болгож өсгөв. Тус агентлагаас Монголын эдийн засаг сайжирч төсвийн орлого болон валютын нөөц нэмэгдсэн явдал зээлжих зэрэглэлийг өсгөхөд хүргэсэн гэж үзэв. Өнгөрөгч онд Монголын эдийн засаг удааширснаар зээл олгох зардал ихэсч, хугацаа хэтэрсэн зээлийн багц нэмэгдэж хүндрэл үүсч улмаар "Fitch" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэг шатаар бууруулж –B зэрэглэлд оруулсан. Эргүүлэн "B" зэрэглэлээр өсгөсөн нь Монгол Улсын Засгийн газарт олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө шууд болон шууд бусаар хүлээсэн өр төлбөрийг богино хугацаанд барагдуулах, төлбөрийн тэнцлийн дарамтад орохоос сэргийлэлт авсан гэж үзсэн байна.

- 2016 онтой харьцуулбал энэ оны 11-р сарын байдлаар шинэ орон сууцны борлуулалт 10 хувиар буурч хуучин орон сууцны борлуулалт нэмэгдэв. Орон сууцны үнийн ерөнхий индекс тус сарын байдлаар өмнөх сараас 0.2 хувиар өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувиар өсөв. Өнгөрсөн сарын үзүүлэлтээр шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ 2 сая 201 мянган төгрөг болсон нь өмнөх сараас 1.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өсчээ. Харин хуучин 2 өрөө байрны дундаж үнэ нь өнгөрсөн сард 71 сая 223 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар, өмнөх сараас 0.8 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна. Зах зээлд 20 мянга гаруй орон сууцны барилгын ажил хүлээгдэж буйгаас бүрэн ашиглалтад орсон нь 5100 айлын орон сууц байгаа юм.

*Эх сурвалж:*

1. *Статистикийн бюллетень, 11-р сар 2017 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 11-р сар 2017 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*